

**АЛБАН ЖУРМЫН  
ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ  
2013 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

## **АГУУЛГА**

### **ӨМНӨХ ҮГ**

Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ  
Албан журмын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирлын мэндчилгээ

### **НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1 Танилцуулга
- 1.2 Бүтэц, зохион байгуулалт

### **ХОЁР. ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ**

- 2.1 Даатгалын сангийн чиглэлээр
- 2.2 Мэдээллийн сангийн чиглэлээр
- 2.3 Сургалт, сурталчилгааны чиглэлээр
- 2.4 Санхүү, дотоод үйл ажиллагаа
- 2.5 Гадаад болон дотоод хамтын ажиллагаа

### **ГУРАВ. ДҮГНЭЛТ**

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт даатгуулагч, даатгагч болон Жолоочийн даатгалын тухай хуулийг хамтран хэрэгжүүлж байгаа байгууллага хамт олон Та бүхэнд Албан журмын даатгагчдын холбооны 2013 оны үйл ажиллагааны тайланг толилуулж байгаадаа баяртай байна.

2013 онд Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөл, Ажлын албаны хамт олон Монгол улсад албан журмын даатгалын тогтолцоог оновчтой, зөв бий болгох, хуулийг амжилттай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг үйл ажиллагааныхаа гол чиглэл болгон ажиллаа.

Мөн холбооны дэргэдэх даатгалын санг бүрдүүлснээр зам, тээврийн ослын улмаас гуравдагч этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлөх боломж бий болж, замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн мэдээллийн нэгдсэн санг өндөр түвшинд хөтлөх суурь тавигдлаа.

Түүнчлэн холбооны Ажлын алба түүний орон нутаг дахь салбаруудаас улсын хэмжээнд зам, тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж, зам, тээврийн ослын тохиолдлын үед иргэдээс ирүүлсэн дуудлагын дагуу шуурхай албаны үйлчилгээг 24 цагаар тасралтгүй үзүүллээ.

Холбооны үндсэн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх салбаруудыг төв орон нутагт байгуулснаар жолоочийн хариуцлагын даатгалын үйлчилгээг иргэдэд ойртуулах нөхцөлийг бүрдүүллээ.

Холбоо нь эрхэм зорилтоо хэрэгжүүлэхийн тулд 2014-2016 он хүртэлх “Стратеги бодлого”-оо тодорхойлон ажиллаж байна.

2014 онд жолоочийн даатгалын мэдээллийн сан, програм хангамж, сүлжээг бий болгож, иргэдэд хүртээмжтэй, өгөөжтэй үйлчилгээг бий болгоно.

Төгсгөлд нь “Жолоочийн даатгалын тухай” хуулийг хамтран хэрэгжүүлж буй нийт байгууллага хамт олон, иргэдэд ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсч 2014 онд идэвхтэй хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Хүндэтгэсэн,

Удирдах зөвлөлийн дарга

Г.ХЭРЛЭН

## АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Удирдах зөвлөл нь Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, даатгуулагч, даатгагч, хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааны явцад хяналт тавих үүрэгтэй. Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөл нь Удирдах зөвлөлийн дарга болон дараах 6 гишүүнээс бүрэлдэнэ.



Б.Нямаа  
Сангийн яамны Санхүүгийн зах зээл,  
Даатгалын хэлтсийн дарга



Б.Жаргал  
ЗТЯ-ны Зам, тээврийн хяналт,  
бүртгэлийн газрын дарга



П.Батбаатар  
Замын цагдаагийн газрын  
дэд дарга



Ж.Бат-Орших  
Монголын даатгагчдын холбооны  
Ерөнхийлөгч,  
Миг даатгал ХХК-ийн гүйцэтгэх  
захирал



Ш.Батчимэг  
Монголын даатгалын зуучлагчдын  
холбооны ерөнхийлөгч



Т.Батзул  
Монгол даатгал ХХК-ийн  
гүйцэтгэх захирал

**Жолоочийн даатгалын тухай хуулиас... /2011.10.06/**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь жолоочийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах, зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**Албан журмын даатгагчдын холбооны дүрмээс...**

*/Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 327 дугаар тогтоол/*

1.1. Албан журмын даатгагчдын холбоо нь Монгол Улсад албан журмын даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй даатгагчдыг нэгтгэсэн, гишүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, албан журмын даатгалыг төлөвшүүлэх ашгийн төлөө бус хуулийн этгээд байна.

6.1. Холбооны эрх барих дээд байгууллага нь Удирдах зөвлөл байна.

6.2. Удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг Санхүүгийн зохицуулах хороо томилно.

6.9. Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхтэй:

6.9.1 Холбооны дүрэм батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах,

6.9.2 Холбооны ажлын албаны бүтэц, орон тоог батлах

6.9.3. Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө болон төсвийг хэлэлцэж батлах, гүйцэтгэлд хяналт тавих, тайланг хэлэлцэх

6.9.3<sup>1</sup> Хорооноос бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн Холбооны гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх:

## ӨМНӨХ ҮГ



Эрхэм хүндэт даатгагч, даатгуулагч, харилцагчид аа. Та бүхнийхээ энэ өдрийн амар мэндийг айлтган мэндчилье. Энэ удаа Албан журмын даатгагчдын холбооны 2013 оны үйл ажиллагааны тайланг Танд өргөн барьж байна.

Монгол Улсад автотээврийн хэрэгсэл болон жолоочийн тоо жилээс жилд өсөхийн хэрээр замын хөдөлгөөний нягтрал нэмэгдэж зам, тээврийн ослын тоо, иргэдэд учрах хохирлын хэмжээ нэмэгдсээр байна. Улсын их хурлаас албан журмын даатгалын анхны хэлбэр болгож тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч нь даатгалтай эсэхээс үл хамааран зам, тээврийн осолд өртсөн гуравдагч этгээд буюу амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэд, байгууллагуудад нөхөн төлбөр олгодог Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тогтолцоог шинээр нэвтрүүлээд хоёр жил, жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгож эхлээд нэг жилийн хугацаа өнгөрлөө.

Холбоо жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлж, жолоочийн хариуцлагын даатгалын мэдээллийн нэгдсэн сан байгуулах, техник, тоног төхөөрөмж, програм хангамжийг бий болгох, төр захиргаа, хууль хяналтын байгууллага, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах, жолоочийн даатгалын санг бүрдүүлэх, түүнийг зарцуулах, хуулинд заасан нөхцөлөөр нөхөн төлбөр олгох, улс орны хэмжээнд шуурхай алба байгуулж ажиллуулах, автомашин, тоног төхөөрөмжөөр хангах, жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэгч байгууллагууд, орон нутагт болон иргэдэд сургалт, сурталчилгаа явуулах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллалаа.

Албан журмын даатгагчдын холбоо өнгөрсөн жилүүдийн үйл ажиллагаандаа дүгнэлт хийж, “Албан журмын даатгагчдын холбооны 2014-2016 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө” боловсруулан батлуулж, үндсэн зорилгоо улам тодорхой болгов.

Бидний 2016 он хүртэлх стратеги зорилт

*АЛСЫН ХАРАА:*

Монгол Улсын даатгалын салбарын хөгжил дэвшлийн тулгуур байж, олон улсын жишигт хүрсэн үйлчилгээ бүхий хариуцлагын албан журмын даатгалын хөгжлийн төв байна.

*ЭРХЭМ ЗОРИЛГО:*

Жолоочийн даатгалын хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах, хариуцлагын даатгалын нөхөн төлбөр олгох найдвартай сан бүрдүүлэх, жолоочийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэхэд оршино.

*ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС:*

- Даатгагч болон даатгуулагч

- Харилцагчид
- Мэргэжлийн өндөр ёс суртахуун бүхий хамт олон
- Сайн засаглал
- Уламжлал ба шинэчлэл

**УРИА:**

Хариуцлагын даатгал таныг хамгаална.

Тайлант онд Холбоо дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

-Холбооны чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Холбооны салбаруудаа Нийслэл, 20 аймагт байгуулж, холбооны үндсэн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлж, хуульд заасны дагуу даатгалын сан бүрдүүлэх, нөхөн төлбөр олгох нөхцөлийг хангах, олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх, замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, даатгалын тохиолдлын бичиг баримтыг шуурхай бүрдүүлж, нөхөн төлбөрийг үнэн зөв тодорхойлох үүрэг бүхий шуурхай албаны болон хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, сургалт сурталчилгаа явуулах зэрэг үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалтыг хийж, хариуцлагын даатгалыг иргэдэд ойртууллаа.

-Жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн санг үнэн зөв бүрдүүлж, програм хангамжуудыг боловсруулж нэвтрүүлэх түүнийгээ суулган ажиллуулах сервер, сүлжээний тоног төхөөрөмжүүдийг бий болголоо. Мөн цахилгаан тэжээлийн найдвартай эх үүсвэр, хөргөлтийн систем бүхий серверийг бий болгож өөрийн гэсэн техник хангамжийн дэд бүтцийг бий болгож чадлаа.

-Даатгалд хамрагдалгүйгээр замын хөдөлгөөнд оролцогч жолоочийг илрүүлэн даатгалд хамруулах хамтарсан шалгалтыг Нийслэл, аймгуудад замын цагдаагийн тасагтай хамтран тогтмол зохион байгуулж байна. Энд даатгагч, зуучлагч нарыг татан оролцуулж, даатгал хийлгэх үйлчилгээг иргэдэд ойртууллаа.

-Даатгалын үйлчилгээг иргэдэд ойртуулах, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор 2013 оны 9 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд “Чингисийн талбай”-д Санхүүгийн Зохицуулах Хороо, “Ард даатгал”, “Бодь даатгал”, “Миг даатгал”, “Монгол даатгал”, “Монре даатгал”, “Номин даатгал”, “Соёмбо даатгал”, “Тэнгэр даатгал”, “Хаан даатгал”, “Практикал” даатгал зэрэг гишүүн даатгалын компаниуд, “Эрсдлийн шийдэл” даатгалын зуучлагчтай хамтран даатгалын нээлттэй өдөрлөгийг зохион байгууллаа. Ер нь хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөн ашиглаж, сургалт сурталчилгааг эрчимтэй хийж чадсанаар даатгуулагчдын тоо ч өсч, хохирол нөхүүлсэн иргэдийн тоо ч эрс өслөө.

Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг даатгагч, даатгуулагчийг цогц байдлаар хамруулан зохион байгуулж, зам, тээврийн ослын улмаас хохирсон иргэд, байгууллагын хохиролд 7.4 тэрбум төгрөгийг 17384 иргэнд өгсөн нь тэдний зүгээс зүй ёсны талархал хүлээж байна.

Бид цаашид Холбооны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж, удирдлагын шилдэг менежменттэй, эрсдлээс хамгаалагдсан хяналтын тогтолцоо бүхий даатгалын сантай, мэдээллийн сангийн нэгдсэн цогц системтэйгээр даатгуулагч, даатгагч, иргэдийнхээ эрх ашгийг хамгаалан хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллах болно.

Жолоочийн хариуцлагын даатгалд тээврийн хэрэгсэл өмчлөгч иргэд, байгууллага бүхэн хамрагдаж, түүний ач тусыг хүртэх болно.

Хүндэтгэсэн,

Д.ЦЭВЭЭНЖАВ

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


**АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ  
2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН****НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:****1.1 Танилцуулга:**

Улсын их хурлаас 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Жолоочийн даатгалын тухай хуулийг баталж, Санхүүгийн зохицуулах хороо 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 301 дугаар тогтоолоор Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, мөн оны 11 сарын 07-ны өдөр Албан журмын даатгагчдын холбоог үүсгэн байгуулж, улсын бүртгэлийн гэрчилгээ авсан. Тус холбоо нь Даатгалын санг бүрдүүлж, нөхөн төлбөр олгох, даатгалын сангийн шуурхай албыг зохион байгуулах, жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, албан журмын даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй даатгагчдын үйл ажиллагаа, уялдаа холбоог ханган зохион байгуулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх сурталчилгаа хийх, даатгагч, даатгуулагч, хохирогчийн эрхийг хамгаалах үүрэгтэй ашгийн төлөө бус хуулийн этгээд юм.

Холбоо нь Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Зам, тээврийн яам, Замын цагдаагийн газар, даатгагчдын болон зуучлагчдын төлөөлөл бүхий удирдах зөвлөлтэй, өдөр тутмын үйл ажиллагааг хуулиар заасан чиг үүргийн дагуу зохион байгуулах ажлын албатай. Ажлын албаны чиг үүргийн хүрээнд Даатгалын сан түүний шуурхай алба, Мэдээллийн сан, Захиргаа хуулийн хэлтэс гэсэн удирдлагын нэгж, нийслэл болон аймгуудад өөрийн салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Даатгалын сангаас нөхөн төлбөр олгох, даатгалын тохиолдлын газарт үзлэг хийх шуурхай албаны чиг үүргийг Холбооны хэмжээнд Даатгалын сан, орон нутагт Холбооны салбарын удирдлагад хамааруулан хэрэгжүүлж байна.

График 1. Бүтэц, зохион байгуулалт:





Холбоо тайлант хугацаанд Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль болон Холбооны дүрэмд заасан чиг үүргээ биелүүлэн ажиллалаа. Тайлант хугацаанд Холбооны нийт бичиг хэргийн эргэлт 1156, үүнээс албан байгууллага, иргэдээс 542 бичиг, өргөдөл, гомдол нийт 73-ыг хүлээн авч, байгууллага, иргэдэд нийт 574 албан бичиг явуулсан байна.

Холбооны Удирдах зөвлөл тайлант хугацаанд 10 удаагийн хуралдаанаар нийт 32 асуудал хэлэлцэн 17 тогтоол, тэмдэглэлээр 21 шийдвэр гаргасан. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанд 3 асуудлыг оруулж хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Гүйцэтгэх захирал нийт 89 тушаал гаргаж ажлын албаны үйл ажиллагааг чиглүүлэн ажилласан.

Холбоо жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдох журам заавруудыг боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулахад санал өгөх, ажлын хэсэгт орж ажиллах зэргээр эрх үүргээ хэрэгжүүлсэн ба жолоочийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой 3 журам, заавар, аргачлал шинээр боловсруулан, 5 журам, зааварт өөрчлөлт оруулсан байна.

Албан журмын даатгагчдын холбооны дүрмийн 3.1-д Санхүүгийн зохицуулах хорооноос албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Холбооны гишүүн байна гэж заасан байдаг. Монгол улсад албан журмын даатгалын үйл ажиллагааг нийслэлд даатгалын 16 компани, орон нутагт даатгалын компанийн 213 салбар, даатгалын 2357 төлөөлөгч эрхлэн явуулж байна.

Холбооны гишүүн даатгалын компаниуд:

1. Ард даатгал
2. Бодь даатгал
3. Ган зам даатгал
4. Гэр даатгал
5. Мандал даатгал
6. Миг даатгал
7. Монгол даатгал
8. Моннис даатгал
9. Монре даатгал
10. Мөнх даатгал
11. Номин даатгал
12. Соёмбо даатгал
13. Тэнгэр даатгал
14. Улаанбаатар хотын даатгал
15. Хаан даатгал
16. Практикал даатгал

Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах төрийн болон даатгалын мэргэжлийн оролцогч, даатгалын үйл ажиллагааг зуучлах 17 компани, даатгалын хохирол үнэлэх 9 компани болон төрийн дараах байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна. Үүнд:

Төрийн байгууллагууд:

1. Санхүүгийн зохицуулах хороо
2. Зам, тээврийн яам
3. Замын цагдаагийн газар
4. Сангийн яам
5. Татварын ерөнхий газар
6. Гаалийн ерөнхий газар
7. Хил хамгаалах ерөнхий газар
8. Улсын бүртгэлийн ерөнхий газар
9. Автотээврийн үндэсний төв
10. Үндэсний дата төв
11. Аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс

Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр 2013 онд Холбоо гишүүн даатгалын компаниудтай хамтран “Даатгалын нээлттэй өдөрлөг”, гишүүн даатгагч байгууллагууд,



Замын цагдаагийн газар, аймгуудын замын цагдаагийн тасагтай хамтран даатгалгүй жолоочийг илрүүлэн даатгалд хамруулах “Хамтарсан шалгалт” хийх зэрэг томоохон арга хэмжээг байнга зохион байгуулж ажиллалаа. Мөн орон нутгийн салбар болон даатгалын компаниудын салбарын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд анхаарал тавьж ажиллалаа.

## ХОЁР: ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ

### 2.1 ДААТГАЛЫН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

*Даатгалын санг бүрдүүлсэнээр хууль хэрэгжих суурь тавигдав.*

“Жолоочийн даатгалын тухай” хуулийн 22 дугаар зүйл, Сангийн сайд, Зам, тээврийн сайдын 2013 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 20/19 тоот тушаал, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2013 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн дугаар 33/37 тоот хамтарсан тушаалыг удирдлага болгон даатгалын сангийн орлогыг төвлөрүүлэв.

2013 онд жолоочийн даатгалын санд хуулийн дагуу төвлөрүүлэх эх үүсвэрээр нийт 2,816,419.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэв. Нийт орлогын дүнд АТӨЯХТ 81.3 хувь буюу 2,290,996.6 мянган төгрөг, даатгагчдаас төвлөрүүлсэн хөрөнгө 16.8 хувь буюу 473,739.0 мянган төгрөг, бусад орлого 51,683.6 мянган төгрөг болсон байна.

2013 онд орлогын төлөвлөгөөг 128.8 хувиар биелүүлж, батлагдсан төлөвлөгөөг 629,599.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлэв. Гүйцэтгэлийн тайланг хүснэгт №1-ээс харна уу.

Хүснэгт №1. Холбооны 2013 оны орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл /2013.12.31, мян.төг/

Д/д	Орлогын төрөл	2012 оны гүйцэтгэл	2013 оны батлагдсан төлөвлөгөө	2013 оны төлөвлөгөө /тодотгосон/	2013 оны гүйцэтгэл
1	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварын 10 хувь		1,650,000.0	1,650,000.0	2,290,996.6
2	Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчдаас төвлөрүүлэх хөрөнгө	340,000.0	420,525.0	473,739.0	473,739.0
3	Жолоочийн даатгалын хууль тогтоомжийн зөрчилд ногдуулсан торгуулийн орлого		100,000.0	20,000.0	
4	Мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсны орлого		1,500.0	1,500.0	3,000.00
6	Гишүүний элсэлт, жилийн татварын орлого	17,750.0	15,000.0	17,000.0	15,000.0
7	Хөрөнгө оруулалтын орлого	7,814.2		15,000.0	23,767.0
8	зээл, тусламж, хандив, бусад орлого	1,840.0		9,580.7	9,916.5
	<b>Орлогын төсвийн нийт дүн</b>	<b>367,404.2</b>	<b>2,187,025.0</b>	<b>2,186,819.7</b>	<b>2,816,419.2</b>

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварын 10 хувиар бүрдүүлсэн орлогыг тухайн орон нутагт байгуулагдсан Холбооны салбаруудын үйл ажиллагааг санхүүжүүлэх, зам, тээврийн ослоос хохирсон иргэд, байгууллагын хохирлыг нөхөх олговрыг санхүүжүүлэх зэрэг арга хэмжээнд зориулж, санхүүгийн тайланг гаргаж аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэв. Зарим аймагт автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвараар төвлөрүүлсэн орлого зарлагаа бүрэн нөхөж чадаагүй болно.

Даатгалын сангийн хөрөнгийг төвлөрүүлэхэд аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс, орон нутаг дахь салбарууд чухал үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэх нь зүйтэй. Цаашид даатгалын сангийн үйл ажиллагаа, ач холбогдолыг орон нутгийн удирдлага, иргэдэд ойлгуулах ажил чухал хэвээр байсаар байна. Орон нутагт байгаа тээврийн хэрэгсэл даатгалд тэр бүр хамрагдахгүй байгаа явдалд анхаарал төвлөрүүлэх шаардлага ч байгаа юм.

Мөн “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс тус сан буцаан нэхэмжлэх үүрэгтэй.

Даатгалын санд буцаан нэхэмжлэх хөрөнгө 30,818.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд графикайн дагуу төлөгдөж байна.

***Жолоочийн даатгалын сангаас зам, тээврийн ослын улмаас хохирсон иргэд, байгууллагын хохиролд нөхөн төлбөр олгоход бид онцгой ач холбогдол өгч байна.***

“Жолоочийн даатгалын тухай” хуулийн 18 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 365 тоот тогтоолоор шинэчлэн баталсан “Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар”-ыг даатгалын сангаас нөхөн төлбөр олгохдоо мөрдөн ажиллаж байна.

“Жолоочийн даатгалын тухай” хуульд заасны дагуу 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгож эхэлсэн. Тайлант хугацаанд Даатгалын сан нийт 121,633,714 төгрөгийн 98 даатгалын тохиолдлын бичиг баримт хүлээж авсан. Үүнээс 42 нь даатгалын сангийн шуурхай албанаас, 56 нь даатгалын компаниуд болон бусад байгууллага, иргэдээс тус тус хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Даатгалын сангийн Шуурхай албанаас хүлээж авсан “Даатгалын тохиолдлын газар дээрх үзлэгийн тэмдэглэл”-д даатгалын тохиолдолд холбогдогч талууд “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 19.3-д заасан хугацаанд даатгалын санд хандаагүй, мөн заасан хугацаанд жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгоход шаардагдах бичиг баримтын бүрдүүлэлтийг хангаагүй зэрэг үндэслэлээр олгохоос татгалзсан 26 материал /41,149,520 төгрөг/ байна.

2013 оны 12 дугаар сар 31-ний өдрийн байдлаар даатгалын тохиолдлын буруутай этгээд нь үл марган хохирлыг хариуцагч нь шууд барагдуулсан 48 тохиолдлын 28.3 сая төгрөг, Жолоочийн даатгалын сангаас 19 тохиолдлын 40,544,132 төгрөгийг хохирогчдод тус тус олгосон бөгөөд 5 даатгалын тохиолдлын буюу 11,203,230 төгрөгийн нөхөн төлбөрийн материал хянагдаж байна.

## АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2013 онд Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 16 даатгалын компаниас даатгуулагчийн буруугаас болж бусдад хохирол учруулсан 19216 даатгалын тохиолдолд 8,275,184,284 төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

Хохирлыг эрсдлийн ангиллын хувьд авч үзвэл бусдын тээврийн хэрэгсэл, эд хөрөнгөд хохирол учирсан 19044 даатгалын тохиолдолд 8,079,823,181 төгрөгийн нөхөн төлбөр, бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан 172 даатгалын тохиолдолд 195,361,103 төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Даатгалын компани тус бүрийн хохирогчдод олгосон нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээг хүснэгт №2-оос харна уу.

Хүснэгт № 2. Нөхөн төлбөр /Даатгалын компани, эрсдлийн ангиллаар, төг./

№	Даатгагч	Тээврийн хэрэгсэл		Бусад хөрөнгө		Амь нас		Эрүүл мэнд		Нийт даатгалын тохиолдлын тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн нийт дүн
		Даатгалын тохиолдлын тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Даатгалын тохиолдлын тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Даатгалын тохиолдлын тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Даатгалын тохиолдлын тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн		
1	Мөнх даатгал	497	161,603,125	1	708,300	0	0	0	0	498	162,311,425
2	Номин даатгал	1462	565,936,638	3	598,600	0	0	6	10,053,989	1471	576,589,227
3	Миг даатгал	2149	878,609,095	27	24,118,895	3	15,395,000	36	34,320,130	2215	952,443,120
4	Соёмбо даатгал	1585	705,530,786	21	14,058,495	1	5,000,000	8	7,953,765	1615	732,543,046
5	Ард даатгал	1091	464,309,612	12	8,186,067	1	4,579,180	5	5,022,000	1109	482,096,859
6	Монгол даатгал	3631	1,632,383,428	34	18,814,834	2	2,487,265	22	15,059,501	3689	1,668,745,028
7	Моннис даатгал	8	4,977,900	0	0	0	0	0	0	8	4,977,900
8	Тэнгэр даатгал	1470	617,831,407	4	6,107,566	2	2,628,766	8	6,232,820	1484	632,800,559
9	Бодь даатгал	4139	1,570,554,773	26	11,384,209	35	34,148,137	11	18,499,292	4211	1,634,586,411
10	Монре даатгал	903	351,699,970	2	191,000	1	5,000,000	8	2,037,140	914	358,928,110
11	Улаанбаатар хотын даатгал	4	1,900,400	0	0	0	0	0	0	4	1,900,400
12	Практикал даатгал	1246	622,477,485	11	21,237,607	0	0	16	16,058,785	1273	659,773,877
13	Гэр даатгал	137	54,676,893	0	0	0	0	2	872,200	139	55,549,093
14	Мандал даатгал	416	207,546,520	0	0	1	8,521,733	3	909,200	420	216,977,453
15	Ган зам даатгал	5	9,268,400	0	0	0	0	0	0	5	9,268,400
16	Хаан даатгал	92	56,059,892	1	735,500	0	0	0	0	93	56,795,392
17	АЖДХ	67	68,315,784	0	0	0	0	1	582,200	68	68,897,984
	Нийт дүн	18902	7,973,682,108	142	106,141,073	46	77,760,081	126	117,601,022	19216	8,275,184,284

Жолоочийн даатгалын сангаас шийдвэрлэсэн 68 даатгалын тохиолдлын 48 –ыг даатгалын тохиолдлын буруутай этгээд хариуцан шууд төлсөн болно.

## АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН


Жолоочийн даатгалын 2013 оны хураамжийн орлого, нөхөн төлбөрийн харьцааг авч үзвэл:

Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй 16 даатгалын компани 2013 онд жолоочийн даатгалын хураамжийн орлогоос 15,221,530,093 төгрөгийн хураамжийн орлого олж, 8,206,286,300 төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Хохирол нөхөлтийн харьцаа **54** хувь байна.

Хүснэгт №3. Жолоочийн даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн дүн. /даатгалын компаниар/

№	Нэрс	Нийт хураамжийн дүн /төг/	Олгогдсон нөхөн төлбөрийн нийт дүн /төг/	Хураамжийн орлогод нөхөн төлбөрийн эзлэх хувь
1	Мөнх даатгал	197,779,080	162,311,425.00	82
2	Номин даатгал	1,246,243,030	576,589,227.00	46
3	Миг даатгал	1,870,406,597	952,443,120.00	51
4	Соёмбо даатгал	1,258,477,146	732,543,046.00	58
5	Ард даатгал	1,185,778,543	482,096,859.00	41
6	Монгол даатгал	3,188,146,995	1,668,745,028.00	52
7	Моннис даатгал	34,918,818	4,977,900.00	14
8	Тэнгэр даатгал	943,096,839	632,800,559.00	67
9	Бодь даатгал	2,614,051,918	1,634,586,411.00	63
10	Монре даатгал	588,695,327	358,928,110.00	61
11	УБ хотын даатгал	16,801,201	1,900,400.00	11
12	Практикал даатгал	1,121,463,001	659,773,877.00	59
13	Гэр даатгал	140,485,732	55,549,093.00	40
14	Мандал даатгал	403,227,437	216,977,453.00	54
15	Ган зам даатгал	10,591,966	9,268,400.00	88
16	Хаан даатгал	401,366,466	56,795,392.00	14
	Нийт дүн	15,221,530,093	8,206,286,300.00	54

График 2. Жолоочийн даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн харьцаа



## АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Даатгалын тохиолдын тоог нөхөн төлбөрийн хэмжээгээр нь ангилан авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №4. Нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээ /төг/

№	Нэрс	Даатгалын тохиолдлын тоо	Нөхөн төлбөрийн нийт дүн
1	200,000 хүртэлх	7981	1,023,632,697
2	200,000-500,000 хүртэлх	6963	2,089,032,058
3	500,000-800,000 хүртэлх	2034	1,263,126,380
4	800,000-1,000,000 хүртэлх	645	575,340,690
5	1,000,000-1,500,000 хүртэлх	734	881,145,576
6	1,500,000-2,000,000 хүртэлх	335	576,419,332
7	2,000,000-3,000,000 хүртэлх	266	638,612,618
8	3,000,000-4,000,000 хүртэлх	99	334,042,319
9	4,000,000-5,000,000 хүртэлх	55	246,510,590
10	5,000,000-8,000,000 хүртэлх	90	481,573,011
11	8,000,000-10,000,000 хүртэлх	3	26,917,836
12	10,000,000	11	138,831,177
	Нийт дүн	19216	8,275,184,284

График 3. Нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээ



2013 онд нөхөн төлбөр олгосон 19216 даатгалын тохиолдолоос 8346 даатгалын тохиолдол нь 2012 онд байгуулагдсан гэрээнээс, 10802 даатгалын тохиолдол нь 2013 онд байгуулагдсан гэрээнд хамаарах нөхөн төлбөр байгаагийн 68 нь жолоочийн даатгалын сангаас олгосон байна.

Хүснэгт №5. Нөхөн төлбөр /Гэрээ байгуулагдсан оноор, төг/

Д/д	Даатгалын гэрээ байгуулагдсан он	2013 онд олгосон нөхөн төлбөрийн тоо	2013 онд олгогдсон нөхөн төлбөрийн дүн
1	2012 онд байгуулагдсан гэрээнээс	8346	3,701,846,840
2	2013 онд байгуулагдсан гэрээнээс	10802	4,504,439,460
3	Даатгалын сангаас олгосон	68	68,897,984
	Нийт	19216	8,275,184,284

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

График 4. Даатгалын сангаас нөхөн төлбөр олгохыг хүссэн материалын шийдвэрлэлтийн байдал





График 5. Даатгалын сангаас нөхөн төлбөр хүссэн өргөдлийн бүтэц



Жолоочийн даатгалын сангаас энэ оны эхний хагас жилд 10.3 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосонд дүгнэлт хийхэд тус сангаас нөхөн төлбөр авахад иргэдийн зүгээс бичиг баримт бүрдүүлэхэд хүндрэл үүсч, үйлчлүүлэх иргэдийн дийлэнх нь бага, дунд орлоготой иргэд байв. Даатгалын сангаас нөхөн төлбөр олгохыг хүссэн хүсэлтийн дундаж нь 1.3 сая төгрөг байна. “Жолоочийн даатгалын тухай” хуулийн агуулга нь зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирогчдын эрх ашгийг хамгаалах зорилготой тул хохирсон иргэдэд нөхөн төлбөрийг түргэн шуурхай олгохын тулд Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 377 тоотор баталсан “Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар”-т холбогдох өөрчлөлт оруулав. Энэхүү өөрчлөлтийг оруулснаар жолоочийн даатгалын сан нь барьцаа хөрөнгө шаардахгүйгээр нөхөн төлбөрийг олгох бүрэн боломжтой болсон юм. Ингэснээр жолоочийн даатгалын санд хандах иргэдийн хүсэлт нэмэгдэж, сайшаалтайгаар хүлээн авах болсон юм.

График 6. Даатгалын сангаас дараах тохиолдолд нөхөн олговор олгож байна /хуулийн заалт/





График 7. Иргэдийн хандалд журамд өөрчлөлт оруулахаас өмнө, оруулсны дараа




Даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо болон Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлж ажилласан.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 18-р дугаар зүйлд заасан тохиолдол аль болох гаргахгүйн тулд сургалт, сурталчилгаа болон хяналт шалгалт хийж, тээврийн хэрэгслийг даатгалд хамруулах арга хэмжээнүүд авсан нь үр дүн өгч байна.

## АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

График 8. Нөхөн төлбөр олголтыг даатгалын компаниар авч үзвэл /мянган төгрөг/



Хүснэгт №6. Нөхөн төлбөр олголтыг авч үзвэл /газар нутгийн байршлаар/

№	Гарал	Даатгалын тохиолдлын тоо	Нөхөн төлбөрийн дүн
1	Улаанбаатар хот	17696	7,286,946,530.00
2	Орхон	389	178,048,215.00
3	Дархан-Уул	258	139,704,914.00
4	Архангай	29	27,842,236.00
5	Баянхонгор	19	9,513,665.00
6	Баян-Өлгий	65	26,439,019.00
7	Булган	35	35,146,760.00
8	Говь-Алтай	27	9,856,373.00
9	Говь-Сүмбэр	27	32,172,999.00
10	Дорноговь	70	44,171,295.00
11	Дорнод	59	33,734,736.00
12	Дундговь	17	4,795,874.00
13	Завхан	17	6,921,850.00
14	Өвөрхангай	38	25,015,259.00
15	Өмнөговь	64	76,864,234.00
16	Сүхбаатар	21	16,252,791.00
17	Сэлэнгэ	111	89,506,488.00
18	Төв	103	151,234,044.00
19	Увс	31	11,110,270.00
20	Ховд	32	17,846,600.00
21	Хөвсгөл	47	21,704,138.00
22	Хэнтий	61	30,355,994.00
	Нийт	19216	8,275,184,284.00



**Жолоочийн даатгалд даатгуулсаныг гэрчлэх даатгалын баталгааг даатгуулагчид өгнө.**

Жолоочийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйл, Хууль зүй дотоод хэргийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2012 оны А/22/23 тоот хамтарсан тушаалын дагуу даатгагч даатгуулагчтай даатгалын гэрээ байгуулсан даруйд гэрээ байгуулсныг гэрчлэх даатгалын баталгааг даатгуулагчид өгөх үүрэгтэй байдаг. Даатгалын баталгааны загварын эхийг бэлтгэх, захиалга авах, хэвлүүлэх, тараах асуудлыг тус сан хариуцан гүйцэтгэдэг. Тайлант хугацаанд нийт 604.600 баталгааны наалтыг даатгагч нарт олгоод байгаагаас нэгдүгээр улиралд 171.500, хоёрдугаар улиралд 196.511, гуравдугаар улиралд 117.281, дөрөвдүгээр улиралд 90.000 ширхэгийг тус тус олгожээ. Гүйцэтгэлээр 460.1 мянган баталгаа ашиглагдсан байна.

Тус Холбооны мэдээллийн сангийн мэдээллээр нийт 399.370 даатгалын гэрээ байгуулагдсан нь баталгааны наалтыг хэвлүүлэх, хэвлүүлэх тоог хязгаарлах, ашиглах үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах шаардлага байгаа нь харагдаж байна.

График 9. Даатгалын баталгааны захиалга, зарцуулалтын байдал, 2013 он




График 10. Даатгалын баталгааны 2013, 2014 онуудын загвар



Дээр дурдсан хамтарсан тушаалын дагуу даатгалын баталгаа нь тухайн даатгал авагдсан он, соёмбо бүхий зураасан тэмдэгтээр хураангуйлан “тухайн даатгал, татвар, үзлэг, оношилгоо”-ны талаарх мэдээллийг агуулж, радио давтамжит танигчтай байна гэж заасныг 2015 оноос хэрэгжүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна. Тухайлбал Замын цагдаагийн газартай нэгдсэн сүлжээнд холбогдож, харилцан мэдээлэл солилцох бүрэн боломжтой бөгөөд код унших төхөөрөмжтэй болоод байна. Жолоочийн даатгалын баталгааны 2014 онд хэрэглэгдэх загварыг Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны А/274/307 тоот хамтарсан тушаалаар баталсан бөгөөд үнэт цаасны дугаарыг QR шугаман кодоор илэрхийлж 2 талд нь хэвлэсэнээрээ онцлогтой юм. Энэхүү кодыг хэвлэсэнээр зам дээр хяналт тавьж байгаа замын цагдаагийн байцаагч тусгай төхөөрөмжөөр уншиж, тээврийн хэрэгслийн өмчлөгч нь даатгалтай эсэхийг шалгах боломжийг олгох юм. Мөн даатгалын компаниуд даатгалын баталгааны дугаарыг програмд шивэх үйл ажиллагааг хөнгөвчлөх боломжтой болно.

Даатгалын компаниуд Хууль зүй, дотоод хэргийн сайд, СЗХ-ны даргын хамтарсан 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/22/23 дугаар тушаалын 1-р хавсралт “Жолоочийн даатгалын баталгааны загварыг хэрэглэх журам”-ыг үл хэрэгжүүлж, даатгалын баталгааны зарцуулалтын тайланг Холбоонд ирүүлэхгүй байх, алдаатай буруу, дутуу тайлагнах, даатгалын компаниудын хийсэн жолоочийн даатгалын гэрээний тоо нь зарцуулсан наалтын тооноос зөрүүтэй байх, даатгалын баталгааны наалтыг алдаж үрэгдүүлсэн, бусдад ашиглуулсан зэрэг дутагдлууд гарч байгаа нь анхаарал зүй ёсоор татаж байна.



Хүснэгт №7. Даатгалын тохиолдлын байдал

Д/д	Нийслэл болон аймгууд	Нийт дуудлага	Даатгалын тохиолдлын дуудлага	Даатгалын тохиолдлын бүрдүүлсэн материал	Хамтарч шалгасан машины тоо	Илрүүлсэн зөрчил
1	Архангай	16	6	0	-	-
2	Баян-Өлгий	6	0	0	350	52
3	Баянхонгор	10	4	4	375	37
4	Булган	78	2	2	741	189
5	Говь-Алтай	187	0	0	521	48
6	Дархан-Уул	64	8	8	3778	572
7	Дорноговь	12	5	2	102	32
8	Дорнод	5	1	0	160	12
9	Дундговь	46	1	-	139	58
10	Завхан	36	0	0	109	47
11	Орхон	294	183	164	1133	79
12	Өвөрхангай	36	12	12	1070	550
13	Өмнөговь	121	64	50	2153	77
14	Сүхбаатар	62	0	0	54	23
15	Сэлэнгэ	10	0	0	246	55
16	Төв	74	31	31	2047	86
17	Ховд	394	2	1	264	54
18	Хөвсгөл	71	5	1	52	36
19	Хэнтий	42	0	0	-	-
20	Увс	56	0	0	100	26
21	Улаанбаатар	3258	662	588	5400	2318
	<b>Бүгд</b>	<b>4878</b>	<b>986</b>	<b>855</b>	<b>18804</b>	<b>4351</b>

Холбооны орон нутаг дахь салбарууд тайлант хугацаанд орон нутгийн төр захиргааны ажилтан, албан хаагчид болон иргэд олон нийтэд хуулийн ач холбогдлыг таниулах сургалтыг тогтмол зохион байгуулж, орон нутгийн замын цагдаагийн тасагтай хамтран ажиллаж даатгалд хамрагдалгүйгээр замын хөдөлгөөнд оролцсон 1268 тээврийн хэрэгслийг илрүүлэн даатгалд хамруулсан байна. Дээрх үйл ажиллагааны дүнд жолоочийн даатгалын талаар иргэд тодорхой ойлголттой болж, жолоочийн даатгалын ач холбогдол, бусдын өмнө хүлээх хариуцлага дээшилж, нийгэмд эерэг уур амьсгал бүрдэж байна.

***АЖДХ-ны Орон нутаг дахь салбарууд 2013 онд сургалт, сурталчилгаа, хяналтын чиглэлээр ажилласан байдал /фото мэдээлэл/***

***Баян-Өлгий аймаг***



Төв талбайд байрлах дэлгэцээр хууль сурталчилж байна.



Бугат суманд сургалт явуулж байна



ЗЦТ-тай хамтарсан шалгалт явуулж байна



АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

**Булган аймаг**



Булган аймагт даатгалд хамруулах хийв.



ЗЦТ-тай нягт хамтран ажиллаж байна.



ЗЦТ-тай хамтарсан шалгалт шалгалтын аян эхэллээ

**Дархан Уул аймаг**



Ногоон гэрэл цаган шугам тэмцээнд



Дархан орон нутгийн телевизд ярилцлага өгч байна



ЗЦТ-тай хамтарсан шалгалт

**Завхан аймаг**



ЗЦТ-тай хамтарсан шалгалт зохион байгууллаа



Иргэдэд сургалт явуулж байна

**Өмнөговь аймаг**



ЗЦТ-тай хамтарсан шалгалт явуулж байна.

**Увс аймаг**



Улаангом сумын ЗДТГ-ын ажилтан албан хаагчид, иргэдэд сургалт хийв.



Улаангом сумын багийн засаг дарга нарт сургалт явуулж байна



Орон нутгийн сургуулийн багш нарт сургалт хийв.

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

**Сүхбаатар аймаг**



Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн тасаг, Даатгалын компаниуд, иргэд, жолооч нарын төлөөлөлд Баруун-Урт сумын ЗДТГазартай хамтран зохион байгуулсан сургалт

**Хөвсгөл аймаг**



Сургалт явуулж байна

**Ховд аймаг**



Аймгийн засаг дарга, даатгалын компаниудын менежерүүд, Замын цагдаагийн байцаагч нарын “Хамтарсан уулзалт-2”

**Өвөрхангай аймаг**



Хариуцлагаа сайжруулъя-аюулгүй замын хөдөлгөөн” аян явуулав

Мөн энэхүү хяналт шалгалтын зэрэгцээ хууль сурталчлах чиглэлээр гарын авлага тараах материалыг боловсруулан олон нийтэд түгээж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр холбогдох богино хэмжээний нэвтрүүлэг зэргийг цацаж, иргэдэд мэдээ мэдээллийг шуурхай хүргэж ажиллалаа.

Даатгалын сангийн шуурхай алба Нийслэлд 70101177 тоот утсаар, орон нутагт доорх утсуудаар даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг 24 цагийн турш хүлээн авч, шуурхай албаны үйлчилгээ үзүүлж байна.



## АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Хүснэгт №8. Орон нутгийн салбаруудын холбоо барих утас, хаяг

д/д	Аймаг	Овог нэр	Утас	Цахим шуудан
1	Архангай	Н.Данинов	94773570	arkhangai@ami.mn
2	Баянхонгор	Ц.Отгонбаяр	94724070	bayankhongor@ami.mn
3	Баян-Өлгий	Х. Нуртилек	95483570	bayanulgii@ami.mn
4	Булган	М.Алтанхүү	94533570	bulgan@ami.mn
5	Говь-Алтай	Л.Мөнх-Эрдэнэ	94323570	govialtai@ami.mn
6	Дархан	С.Сугар	94714050	darkhan@ami.mn
7	Дорнод	Д.Дуулиан	94734070	dornod@ami.mn
8	Дорноговь	М.Баасанжав	94714070	dornogovi@ami.mn
9	Дундговь	О.Сэргэлэн	94513570	dundgovi@ami.mn
10	Завхан	П.Эрдэнэ-Очир	94273570	zavkhan@ami.mn
11	Орхон	С.Шагж	94724050	orkhon@ami.mn
12	Өвөрхангай	Д.Батчулуун	94754050	uvurkhangai@ami.mn
13	Өмнөговь	Б.Амгалан	94734050	umnugovi@ami.mn
14	Сүхбаатар	М.Төмөрчулуун	95213570	sukhbaatar@ami.mn
15	Сэлэнгэ	Э.Баатархуяг	94673570	selenge@ami.mn
16	Төв	Ц.Ганбаатар	94754070	tuv@ami.mn
17	Хөвсгөл	Б.Сэргэлэн	95413570	khuvsgul@ami.mn
18	Ховд	Б.Алтанбадралт	94793570	khovd@ami.mn
19	Хэнтий	С.Энхмөнх	94523570	khentii@ami.mn
20	Увс	Т.Алтанцэцэг	95293570	Uvs@ami.mn
21	Нийслэл	С.Пионер	95493570	niislel@ami.mn

Дээрх шуурхай албадын утсаар зөвхөн даатгалын тохиолдлын дуудлага хүлээн аваад зогсохгүй иргэдийн сонирхсон асуултын дагуу лавлагаа, тодруулга, зөвлөгөө өгч шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийг даатгагч нартай холбож, бусад боломжит мэдээллээр ханган ажиллалаа.

## 2.2 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫГ АМЖИЛТГАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ ҮНЭН ЗӨВ БҮРДҮҮЛЭХ ЯВДАЛ ЮУ ЮУНААС ЧУХАЛ БАЙХ БОЛНО.

Жолоочийн даатгалын мэдээллийн сан нь 24 цагийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажилласан. Мэдээллийн сан нь 2013 онд даатгуулагчийн жолоочийн даатгалын түүхийг холбогдох хууль, журмын дагуу бүрдүүлэх, хохирлын хэмжээг зөв үнэлж нөхөн төлбөр олгох, даатгалын гэрээ хийхдээ итгэлцүүр ашиглан хураамжийг тооцоолох, даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч болон хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах үүрэг бүхий төрийн байгууллагуудтай мэдээлэл харилцан солилцох үндсэн үүргийг цахим хэлбэрээр гүйцэтгэх боломжийг бүрдүүлээ.

Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ашиглагдах дараах төрлийн програмыг боловсруулж, нэвтрүүлсэн. Үүнд:

Мэдээллийн сан:

1. Жолоочийн даатгалын мэдээллийн сан
2. Даатгалын сангийн нөхөн төлбөрийн бүртгэлийн мэдээллийн сан

Програм:

1. Мэдээллийн сангийн үндсэн бүртгэлийн програм.
2. Даатгагчдаас жолоочийн даатгалын мэдээлэл хүлээн авах програм.
3. Даатгагчдад цахим лавлагаа олгох програм.
4. Дотоод хэрэглэгчдэд цахим лавлагаа олгох програм.



## АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

5. Даатгагчтай мэдээлэл солилцох програм.
6. Төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох програм.
7. Шуурхай албаны бүртгэлийн програм.
8. Нөхөн төлбөрийн бүртгэлийн програм.

Холбооны гишүүн 16 даатгалын компанийн жолоочийн даатгалын үйл ажиллагаанд ашиглагдах програмуудыг мэдээллийн сангийн програмтай уялдуулж нийцүүлсний үндсэн дээр Жолоочийн даатгалын мэдээллийн сантай холбож мэдээлэл харилцан солилцох үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэв. Мэдээллийн сан энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлснээр Жолоочийн даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам, Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам болон холбогдох бусад журам зааврыг үнэн зөвөөр хэрэгжүүлэх үндсэн суурь тавигдлаа. Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн програмуудыг суулган ажиллуулах техник хангамжийн дэд бүтцийг бий болгосон. Мэдээллийн сангийн үндсэн системүүдийг Холбоо болон Үндэсний дата төв дээр хосолсон холболт, нөөц хувилбартайгаар ажиллуулах боломж бүрдүүлээд байна. 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Жолоочийн даатгалын мэдээллийн санд дараах мэдээлэл бүртгэгдээд байна.

## Хүснэгт №9. Жолоочийн даатгалын гэрээ

<b>Жолоочийн даатгалын гэрээ: 676018</b>	<b>Үндсэн мэдээлэл:</b>
- 2012 он: <b>274502</b>	- Хувь хүний мэдээлэл: <b>540733</b>
- 2013 он: <b>401516</b>	- Хуулийн этгээдийн мэдээлэл: <b>16752</b>
<b>Нөхөн төлбөр: 21694</b>	- Тээврийн хэрэгслийн мэдээлэл: <b>522273</b>
- 2012 он: <b>5117</b>	
- 2013 он: <b>17286</b>	

Холбооны гишүүн даатгалын компани жолоочийн даатгалын үйл ажиллагааг хөнгөвчлөх, даатгуулагчид үзүүлэх үйлчилгээг хурдан шуурхай, боловсронгуй болгох зорилгоор Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн лавлагааг цахим хэлбэрээр олгож эхэлсэн. 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Холбооны гишүүн даатгалын компани болон даатгалын зуучлагч компаниудад даатгуулагч болон тээврийн хэрэгслийн талаарх дараах лавлагаа олгосон байна.

## Хүснэгт №10. Жолоочийн даатгалын гэрээ

№	Даатгалын компани	Лавлагааны төрөл		Нийт дүн
		Вэб	Сервис	
1	Мөнх даатгал	371	3809	4180
2	Номин даатгал	3164	65638	68802
3	Миг даатгал	402	71133	71535
4	Соёмбо даатгал	928	5906	6834
5	Ард даатгал	1084	48355	49439
6	Монгол даатгал	12706	123246	135952
7	Моннис даатгал	40	243	283
8	Тэнгэр даатгал	21	100080	100101
9	Бодь даатгал	8079	198655	206734
10	Монре даатгал	4336	36786	41122
11	Улаанбаатар хотын даатгал	9	465	474
12	Практикал даатгал	1294	48069	49363
13	Гэр даатгал	1674	6882	8556
14	Мандал даатгал	6163	33501	39664
15	Ган зам даатгал	148	1528	1676
16	Хаан даатгал	705	17467	18172
Нийт дүн		41124	761763	802887



## АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Зам, тээврийн яам болон Замын цагдаагийн газартай хамтарсан ажлын хэсэг байгуулж мэдээллийн сангуудыг харилцан холбож мэдээлэл солилцох үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Замын хөдөлгөөнд хяналт тавьж буй Замын цагдаагийн газрын байцаагч болон автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтөлж буй Зам, тээврийн яамны ажилтан нь тухайн тээврийн хэрэгслийн өмчлөгч даатгалд хамрагдсан эсэхийг жолоочийн даатгалын мэдээллийн сангаас шалгах боломж бүрдсэн бөгөөд хяналтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мэдээллийн сангийн 2013 оны энэхүү үйл ажиллагааны үр дүнд даатгалын салбарт үүсч буй анхны мэдээллийн нэгдсэн сан бий болж даатгалын компаниуд үйл ажиллагаандаа үр дүнтэйгээр ашиглаж эхэлсэнээр жолоочийн даатгалын үйл ажиллагаанд гарч буй хууль бус үйлдлийг бууруулан, даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой алхам боллоо.

**Жолоочийн даатгалын гэрээг үнэн зөв, тухай бүр мэдээллийн санд оруулсанаар даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, дараа жилийн гэрээний хураамжийг үнэн зөв тогтоох боломж олгохын зэрэгцээ судалгаа хийх, хяналт тавих бааз бий болно.**


Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 16 даатгалын компани 2013 онд 419357 даатгалын гэрээ байгуулж, 15,221,530,093 төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсон байна.

Даатгалын гэрээг ангиллын хувьд авч үзвэл хувь хүний 362677, хуулийн этгээдийн 51335, мэргэшсэн болон “С”, “D” ангиллын жолоочийн 5345 гэрээ байгуулагдсан байна. Үүнийг даатгалын компани тус бүрээр авч үзвэл:

Хүснэгт №11. Жолоочийн даатгалын гэрээ, хураамжийн дүн /Даатгалын компани болон гэрээний ангиллаар/

№	Нэрс	Хувь хүн		Хуулийн этгээд		Мэргэшсэн, CD		Нийт гэрээний тоо	Нийт хураамжийн дүн
		Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн		
1	Мөнх даатгал	4252	139,595,931	679	55,450,749	85	2,732,400	5016	197,779,080
2	Номин даатгал	29835	964,282,856	3827	268,738,919	399	13,221,256	34061	1,246,243,030
3	Миг даатгал	39633	1,257,876,702	8195	605,694,522	207	6,835,373	48035	1,870,406,597
4	Соёмбо даатгал	25982	802,231,562	5696	433,545,131	682	22,700,453	32360	1,258,477,146
5	Ард даатгал	26723	831,365,928	4805	335,469,279	555	18,943,337	32083	1,185,778,543
6	Монгол даатгал	82903	2,489,250,569	8665	633,876,560	1952	65,019,866	93520	3,188,146,995
7	Моннис даатгал	43	1,551,363	297	29,274,300	128	4,093,155	468	34,918,818
8	Тэнгэр даатгал	18698	566,949,097	4472	375,908,629	7	239,113	23177	943,096,839
9	Бодь даатгал	67391	2,147,516,669	6549	435,913,804	912	30,621,445	74852	2,614,051,918
10	Монре даатгал	14442	457,498,564	2110	129,183,763	61	2,013,000	16613	588,695,327
11	Улаанбаатар хотын даатгал	53	1,773,518	145	12,316,733	88	2,710,950	286	16,801,201
12	Практикал даатгал	32079	982,424,641	2006	132,837,825	180	6,200,535	34265	1,121,463,001
13	Гэр даатгал	2827	101,014,794	682	39,444,538	1	26,400	3510	140,485,732
14	Мандал даатгал	7223	240,252,677	2114	161,906,698	33	1,068,062	9370	403,227,437
15	Ган зам даатгал	70	2,468,152	117	7,561,164	18	562,650	205	10,591,966
16	Хаан даатгал	10523	333,084,391	976	67,133,674	37	1,148,401	11536	401,366,466
Нийт дүн		362677	11,319,137,412	51335	3,724,256,285	5345	178,136,396	419357	15,221,530,093

График 11. Жолоочийн даатгалын гэрээ /Даатгалын компаниар/




Жолоочийн хариуцлагын даатгалын гэрээг байгуулж, зохих хураамжийг авсан боловч мэдээллийн нэгдсэн санд тухай бүр оруулахгүй тохиолдол нийтлэг байгаа төдийгүй даатгал хийж хураамжийн орлого авахыг илүү сонирхож байгаа нь ажилд ихээхэн хохирол учруулж байна. Тухайлбал 2013 оны мэдээллийн санд Ард даатгал 4808, Тэнгэр даатгал 2128, Номин даатгал 4015, Практикал даатгал 4951 зэрэг бүгд 24413 гэрээний мэдээлэл нэгдсэн санд ороогүй болно.

**2013 оны жолоочийн даатгалын хамрагдалт, нөхөн төлбөрийн идэвхжилтийн судалгаа**

Жолоочийн даатгалд хамрагдалт 2013 оны 4-6, 9-10 саруудад хамгийн өндөр буюу 265925 даатгалын гэрээ байгуулагдсан байна. Энэ нь 2013 онд байгуулагдсан нийт гэрээний 66.23% хувьтай тэнцүү байна.


График 12. Жолоочийн даатгалд хамрагдалт /сараар/



## АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2013 онд даатгалын тохиолдол болон нөхөн төлбөр олголтын хэмжээг 2012 онтой харьцуулахад 3.1 дахин өссөн байна. 2013 онд дунджаар сар бүр 1446 даатгалын тохиолдолд 616,042,706 төгрөгийн нөхөн төлбөр олгожээ.

График 13. Даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн идэвхжилт /сараар/




Хүснэгт №12. Жолоочийн даатгалын гэрээ /газар нутгийн байршлаар/

№	Нийслэл болон аймаг	Даатгалын гэрээний тоо	Хураамжийн дүн
1	Улаанбаатар хот	254948	9,996,287,188.21
2	Орхон	13575	499,118,740.10
3	Дархан-Уул	10435	356,516,532.40
4	Архангай	6882	223,796,691.45
5	Баянхонгор	7953	224,262,485.72
6	Баян-Өлгий	7630	212,934,523.37
7	Булган	5460	156,299,597.85
8	Говь-Алтай	6865	203,495,691.46
9	Говь-Сүмбэр	2309	84,343,212.25
10	Дорноговь	7890	277,702,006.46
11	Дорнод	6940	195,571,500.20
12	Дундговь	6648	171,726,195.69
13	Завхан	5467	175,516,460.54
14	Өвөрхангай	10526	316,767,730.09
15	Өмнөговь	9204	423,023,682.18
16	Сүхбаатар	5987	172,263,112.47
17	Сэлэнгэ	10384	338,510,538.35
18	Төв	8986	270,173,370.74
19	Увс	6324	176,565,856.87
20	Ховд	4611	149,843,370.42
21	Хөвсгөл	12880	372,760,056.39
22	Хэнтий	7453	224,051,549.51

## АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Нийт	419357	15,221,530,092.72
------	--------	-------------------

График 11. Жолоочийн даатгалын гэрээний харьцаа /Гэрээний ангиллаар/



### 2.3 ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛЫГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААГ ДААТГАЛД ХАМРАГДАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨШҮҮРЭГ БОЛГОН АШИГЛАВ.

2013 онд жолоочийн даатгалын тухай хуулийг нийтэд сурталчлах, хэрэгжилтийн явц байдалтай танилцах, хууль хэрэгжүүлэгч төрийн болон аж ахуйн нэгж байгууллагууд, даатгалын компанийн ажилтнуудад мэдээлэл хүргэх, мэргэжлийн удирдлагаар хангах, нийгэмд зөв нэгдсэн ойлголт төлөвшүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Завхан, Орхон, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор, Архангай, Өмнөговь, Баян-Өлгий, Ховд, Увс, Дорнод зэрэг 19 аймаг, нийслэлд холбооны 9 ажилтан томилолтоор ажиллав. Орон нутгийн удирдлага, санхүү төрийн сангийн хэлтсийн холбогдох албан тушаалтнуудтай уулзалт ярилцлага зохион байгуулан холбооны үйл ажиллагаа, зорилго, жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгө, хууль хэрэгжүүлэх асуудлаар мэдээлэл солилцох, хамтран ажиллаж, орон нутагт тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудлаар санал солилцож, орон нутгийн төр захиргааны болон даатгалын компаниудын тухайн аймаг дахь салбарын ажилтнууд, замын цагдаа, автотээврийн газар, авто оношилгоо, тээврийн хэрэгслийн бүртгэлийн газрын ажилтнуудад Жолоочийн даатгалын тухай хуулийн талаар сургалт зохион байгуулав.

Орон нутгийн телевиз, радиогоор нийт иргэдэд хуулийн ач холбогдлын талаар мэдээлэл сурталчилгаа явуулсан. Энэхүү орон нутагт зохион байгуулсан сургалтад нийт 2215 хүн хамрагдсан байна.

Нийслэлд хууль сурталчлах чиглэлээр тээврийн хэрэгсэл олноор байршдаг “Нарантуул” худалдааны төв, “Өгөөмөр” зах, “Да хүрээ” зах, “Баян хурах” техникийн зах, Баянзүрхийн товчоо, аймаг дүүргийн Замын цагдаагийн тасаг, тээврийн оношилгооны газар, даатгалын компани тэдгээрийн салбаруудад жолоочийн даатгалын тухай хуулийн заалт бүхий 2000 гаруй анхааруулга, 130 ширхэг мэдээллийн самбар, 277.000 ширхэг тараах материал тарааж, хуулийн талаар мэдээлэл өгч, сурталчилгаа хийсэн. Замын цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран жолооч нарыг зам, тээврийн осол, зөрчлөөс сэргийлэх, Жолоочийн даатгалын тухай хуулийг сурталчлах чиглэлээр 5 төрлийн санамж боловсруулан хэвлүүлж, тус бүр 1500 ширхэг, нийт 7500 ширхэгийг төв, орон нутгийн жолооч нарт хүргүүлж сурталчлав.

Мэдээллийн сангаас Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам, Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журмыг хэрэгжүүлэх зорилгоор хураамжийн дүнг үнэн зөв тооцох, мэдээллийн нэгдсэн санд хэрхэн ашиглах, гэрээний болон нөхөн төлбөрийн мэдээллийг тухай бүрт нь мэдээллийн санд оруулах талаар гишүүн даатгалын компани, даатгалын зуучлагч болон төрийн байгууллагуудын нийт 765 ажилтанд 19 удаагийн сургалтыг Нийслэлд зохион байгууллаа.

Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан сургалт сурталчилгааг эрчимжүүлэх зорилгоор 2013 оны 4 дүгээр сараас 2 сарын хугацаатай аяныг зохион байгуулж,

даатгуулагч жолооч нарт хандсан тус бүр 60 секундын хугацаатай 6 богино нэвтрүүлгийг “МҮОНРадио” болон “Хамаг Монгол 95.1”, “Инээмсэглэл 99.3”, “Шинэ долгион-107.5”, “Их монгол-99.7”, “Элгэн нутаг-96.9”, “Миний монгол-100.5”, “Дотно-103.6”, “Kiss100.1”, “Улаанбаатар 102.5”, “Нандин 105.5”, “FM106”, P3 нийт 13 FM радиогоор 6988 удаа цацан олон нийтийг жолоочийн даатгал хийлгэх, даатгалын хугацаагаа сунгуулах болон даатгал хийлгэсний эерэг үр дүнг сурталчиллаа. Мөн “Жолооч таны төлөө” тус бүр нь 5-7 минутын хугацаатай 4 хэсэгтэй теле нэвтрүүлэг бэлтгэж, “MN25”, “Боловсрол суваг”, “ТВ5”, “Ийгл Тв”, “МҮОНТ”-ээр 48 удаа нэвтрүүллээ.

Монголын хэвлэлийн хүрээлэн, Эдийн засгийн сэтгүүлчдийн клубтэй хамтран Санхүүгийн зохицуулах хороо, Замын цагдаагийн газар, Даатгагчдын холбооны төлөөллийг оролцуулсан “Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн байдал” сэтгүүлчдийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулав. Уг хэлэлцүүлэгт эдийн засгийн чиглэлийн телевиз, радио, сонин, сэтгүүлийн 8 сэтгүүлч оролцож, “Ийгл”, “Эх орон” телевизээр нэвтрүүлэг, мэдээ болгон түгээсэн. Улаанбаатар хотод ажиллаж байгаа оношилгооны газруудын ойр орчимд байрлуулах жолоочийн даатгалын хууль сурталчилсан 16 самбарын эхийг бэлтгэж, хэвлүүлж дээрх байгууллагуудын хариуцсан ажилтанд хүлээлгэн өгч хууль сурталчлав.

Үндэсний шуудан сонины газрын “Редакцийн уулзалт”-ыг зохион байгуулж, “Миг даатгал”, “Монгол даатгал”, “Номин даатгал”, “Мандал даатгал”, “Практикал даатгал”-ын төлөөлөгчдийг оролцуулан сэтгүүлчдийн сонирхсон асуултанд дэлгэрэнгүй хариулж, Жолоочийн даатгалын хуулийн хэрэгжилтийн талаар тус сонинд 2 нүүр материал хэвлүүлж гаргав. “МҮОНРТелевиз”-ийн “Нээлттэй хэлэлцүүлэг” нэвтрүүлэгт Зам, тээврийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Замын цагдаагийн газар, Албан журмын даатгагчдын холбоо, Монголын Даатгагчдын холбоо, даатгалын 16 компанийн төлөөлөл оролцон “Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн явц байдал” сэдвээр хэлэлцүүлэг хийж хуулийн хэрэгжилтийн явцыг танилцуулан жолоочийн даатгалын тухай хуулийг олон нийтэд энгийн ойлгомжтой хэлбэрээр сурталчилж, даатгалд хамрагдах сонирхолыг идэвхжүүлэн даатгалын ашиг тусын талаар олон нийтэд мэдээллээ.

Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлж, жолоочийн албан журмын даатгалд хамрагдаагүй болон хамрагдсан ч даатгалын гэрээний хугацаа нь дууссан жолооч нарт даатгалын нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх замаар даатгалд хамруулах, иргэд олон нийтийг даатгалын үйлчилгээний бүх төрлийн мэдээллээр хангах, даатгалын үйлчилгээ үзүүлэх улмаар зам, тээврийн ослын улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч буй иргэдийн эрх ашгийг хамгаалах, хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2013 оны “Даатгалын нээлттэй өдөрлөг”-ийг Нийслэлийн өдрийг угтан 2013 оны 09 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд Чингисийн талбайд амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгийн хугацаанд нийт 1349 даатгалын гэрээ байгуулж, 2127 иргэнд даатгалын асуудлаар зөвлөгөө өгч, сурталчилгаа хийв.

“Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн санхүүжилтээр Дархан-Уул, Сэлэнгэ аймагт Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран зохион байгуулагдсан “Даатгал таны амьдралд” сургалтад оролцож Баруунхараа, Дархан, Ерөө, Хүдэр, Цагааннуур, Түшиг, Шаамар, Сүхбаатар сумдад “Жолоочийн даатгал таны амьдралд” сэдвээр нийт 517 хүнд жолоочийн даатгалын мөн чанар, ач холбогдлын талаар сургалт явууллаа.

ОХУ-ын Автодаатгагчдын холбооны Дэд ерөнхийлөгч Светлана Васильевна Никитина, Даатгалын газрын захирал Евгений Васильевич Васильев, Ерөнхийлөгчийн зөвлөх Василий Васильевич Балог нарын албан айлчлалын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Замын цагдаагийн газар, Зам, тээврийн яам зэрэг төрийн байгууллагууд, Даатгалын зуучлагчдын холбоо, Даатгалын хохирол үнэлэгчдийн холбоо, гишүүн даатгагч нарын ажилтнууд нийт 60 хүнийг оролцуулан “ОХУ-ын Жолоочийн хариуцлагын даатгалын эрх зүйн тогтолцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулав.

Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх, сурталчлах, иргэдэд зөв ойлголт мэдлэг олгох ажлыг тус холбооны гишүүн 16 даатгалын компаниуд бүх салбар нэгжээрээ дамжуулан харилцагч байгууллага иргэдийнхээ хүрээнд зохион байгуулж, өндөр хандалттай мэдээллийн

## АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

цахим хуудсуудад баннер, мэдээлэл байрлуулах, радио телевизийн өргөн нэвтрүүлгийн сувгууд, богино долгионы радиогоор сурталчилгааны нэвтрүүлгүүдийг байнга явуулах, мэдээллийн самбар, брошурууд хэвлэн олноор тараах, орон нутагт төрийн байгууллагууд, замын цагдаа, төрийн бус болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарсан нэгдсэн ажлууд, нэрэмжит өдөрлөг зохион байгуулах, жолоочийн даатгалын гол сегментүүдэд /аавуудын өдөр, сургуулийн сурагчид/ чиглэсэн сайн үйлсийн аяныг зохион байгуулах зэрэг нийгэмд хандсан сургалт сурталчилгааны ажлуудыг хийлээ.

Жолоочийн даатгалын тухай хуулийг олон нийтэд таниулах, иргэдэд нэгдсэн зөв ойлголт өгөх зорилготой дээрх сургалт, сурталчилгааны ажлын үр дүнд даатгалд хамрагдалт тодорхой хэмжээгээр нэмэгдэж, иргэд жолоочийн даатгалын ач тусыг нааштайгаар хүлээн авч байна.


**Жолоочийн даатгалд хамрагдалт:**

2013 оны жолоочийн даатгалд хамрагдалтын судалгааг дараах 3 хэлбэрээр харьцуулан гаргаж үзүүлэв. 2013 онд жолоочийн даатгалд хамрагдалтыг өмнөх 2012 оны мөн үеийн жолоочийн даатгалын тоон мэдээтэй харьцуулж харуулав. Үүнд:

Хүснэгт №13. Жолоочийн даатгалд хамрагдалт /Өмнөх онтой харьцуулахад/

Д/д	Үзүүлэлт	2012.12.31	2013.12.31
		СЗХ-оос гаргасан тоо	АЖДХ-ны мэдээллийн сан
1	Даатгалын гэрээний тоо	373,480	419,357
2	Даатгалын хураамж /төг/	16,298,075,693.9	15,221,530,093
3	Нөхөн төлбөр авсан тоо	9,521	19,216
4	Олгосон нөхөн төлбөр /төг/	4,790,865,946.4	8,275,184,284.00
<b>Жолоочийн даатгалд хамрагдалт</b>		<b>12.28 хувиар өсөв</b>	

График 12. Жолоочийн даатгалд хамрагдалт



2013 онд техникийн хяналтын үзлэг, оношилгоонд хамрагдсан, татвар төлсөн болон улсад бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн тоотой харьцуулахад жолоочийн даатгалд хамрагдалт дараах байдалтай байна.

График 13. Тээврийн хэрэгслийн бүртгэл, оношилгоо, татвар болон жолоочийн даатгалын тоон үзүүлэлт /2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар/

График 13. Жолоочийн даатгалд хамрагдалт /мэргэшсэн жолоочийн гэрээний тоо ороогүй/



Хүснэгт №14. Жолоочийн даатгалд хамрагдалт

Харьцуулалт	Жолоочийн даатгалд хамрагдалт
ЗТЯ-ны нийт тээврийн хэрэгслийн бүртгэлтэй харьцуулахад	60.73%
АТҮТ-н оношилгоонд орсон нийт тээврийн хэрэгсэлтэй харьцуулахад	95.81%

Бодитойгоор замын хөдөлгөөнд идэвхтэй оролцогч тээврийн хэрэгслийн тоотой харьцуулахад 2013 онд жолоочийн даатгалд хамрагдалт дараах байдалтай байна. Үүнд:

- 2012 онд нийт 373.344 тээврийн хэрэгсэл, 2013 онд нийт 413.692 тээврийн хэрэгсэл оношилгоонд орсон байна.
- 2013 онд нийт 72.055 тээврийн хэрэгсэл шинээр бүртгүүлж, улсын дугаар авсан байна.

Монгол улсад бүртгэлтэй боловч даатгалд хамрагддаггүй тээврийн хэрэгслүүд байсаар байна. Иймд жолоочийн даатгалд хамрагдалтыг бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн мэдээтэй харьцуулан гаргах боломжгүй байна.

Хүснэгт №15. Жолоочийн даатгалд хамрагдалт. /мэргэшсэн жолоочийн гэрээний тоо ороогүй/

№	Аймаг, нийслэл	Монгол улсад бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн тоо	Оношилгоонд орсон нийт тээврийн хэрэгслийн тоо	АТӨЯХАТ төлсөн тээврийн хэрэгслийн тоо	Жолоочийн даатгалын гэрээний тоо
1	Архангай	9014	7810	7000	6,698
2	Баянхонгор	14231	8690	6,188	7,551
3	Баян-Өлгий	14574	7255	5,056	7,233
4	Булган	9495	7451	5,412	5,180
5	Говь-Алтай	7989	6937	6,901	6,617
6	Говьсүмбэр	2373	2984	1,553	2,147
7	Дархан	17161	9841	8,716	10,084
8	Дорноговь	14420	11006	9,490	7,476
9	Дорнод	12595	8209	8,211	6,365
10	Дундговь	7198	6685	3,704	6,263
11	Завхан	10427	7291	5,300	5,265
12	Орхон	18707	11370	12,853	12,975



13	Өвөрхангай	14929	10247	9,150	9,909
14	Өмнөговь	17004	16676	13,531	8,310
15	Сүхбаатар	8975	6831	3,393	5,540
16	Сэлэнгэ	16599	11955	9,213	9,722
17	Төв	12237	10766	6,734	8,687
18	Увс	10185	7711	5,019	5,529
19	Ховд	11951	7196	5,466	4,424
20	Хөвсгөл	17299	12923	8,533	12,421
21	Хэнтий	8631	7244	5,172	7,093
22	Улаанбаатар	396722	226614	233,275	240,863
Нийт		652,716	413,692	379,870	396,352

2012 онд оношилгоонд хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн тоон дээр 2013 онд импортоор орж ирж шинээр бүртгэгдэж улсын дугаар авсан нийт тээврийн хэрэгслийн тоог нэмж тооцоход 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 445399 тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцож, татвар, даатгал, оношилгоонд хамрагдах ёстой.

Иймд 2013 оны жолоочийн даатгалд хамрагдалтын судалгааг бодитойгоор замын хөдөлгөөнд оролцогч тээврийн хэрэгслийн тоотой харьцуулж гаргахад дараах байдалтай байна.

Хүснэгт №16. Жолоочийн даатгалд хамрагдалт  
/Идэвхтэй ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлтэй харьцуулахад/

№	Харьцуулалт	Тоон мэдээлэл
1	Идэвхтэй ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэл	445399
2	2013 онд байгуулагдсан жолоочийн даатгалын гэрээ	396352
Жолоочийн даатгалд хамрагдалт		88.98 %

## 2.4 ХОЛБООНЫ ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тайлант хугацаанд Холбооны үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн баримт бичгүүд болох “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталж, өдөр тутмын үйл ажиллагаанд дотоод хяналтын програм ашиглах болсонтой уялдуулан “Дотоод хяналтын програм ашиглах тухай”, Холбооны салбарыг орон нутагт байгуулсантай холбогдуулж “Холбооны орон нутаг дахь салбарын ажиллах журам” шинээр боловсруулан баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Холбооны боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, мэргэшүүлэх зорилгоор дотоод нөөцөө ашиглан харилцан суралцах зарчмын дор гадны ижил үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын туршлагыг судлан ажилтнууд харилцан мэдээлэл солилцох богино хэмжээний сургалыг зохион байгууллаа.

Мөн Холбооны удирдлагын нэгжүүд тус тусын үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд орон нутаг дахь салбаруудын үйл ажиллагааг Холбооны ажлын албаны үйл ажиллагаатай уялдуулан салбарын менежер болон дуудлагын ажилтнуудад 3 удаа дотоод сургалтыг зохион байгуулж, сургалтын төгсгөлд мэдлэг сорих шалгалтыг авч дүгнэв.

### *Холбооны санхүү төсвийн талаар:*

Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөл 2013 үйл ажиллагааны төсвийн зардлыг зүйл бүрээр баталж өгсөн. Үйл ажиллагааны төсөв 709339.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалтыг 412815.0 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн гүйцэтгэлийг хүснэгт №17-оос харна уу.

Хүснэгт №17. Холбооны 2013 оны зардлын гүйцэтгэл /2013.12.31-ний байдлаар, мян.төг/

Д/д	Зардлын зүйл, төрөл	Мөрийн дугаар	2012 оны гүйцэтгэл	2013 оны батлагдсан төлөвлөгөө	2013 оны төсөв /тодотгосон/	2013 оны гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэл /+ хэмнэлт, - хэтрэлт/
<b>1. Үндсэн үйл ажиллагааны зардлын төсөв</b>							
1	АЖДХ-ны цалин хөлс	1	167,014.3	327,480.0	298,600.0	298,502.2	97.8
2	Нийгмийн даатгалын шимтгэл /ажил олгогчийн/	2	17,836.5	36,022.8	32,085.5	31,305.2	780.3
3	Удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн урамшуулал	3	26,600.0	28,800.0	18,600.0	17,254.7	1,345.3
4	Томилолтын зардал	4	9,539.6	54,300.0	13,000.0	12,035.1	964.9
5	Захиргаа аж ахуйн зардал Үүнээс:	5	17,460.2	20,741.9	17,894.4	15,426.0	2,468.4
	Захиргаа, аж ахуйн зардал	6	6,586.7	9,374.9	12,450.0	11,088.4	1,361.6
	Бичиг хэргийн зардал	7	3,681.9	8,782.5	5,041.9	4,337.6	704.3
	Даатгал, оношилгоо, татвар	8	7,191.6	2,584.5	402.5	-	402.5
6	Конторын байр, гаражийн түрээсийн зардал	9	20,829.5	175,009.0	158,432.6	157,523.5	909.1
7	Шатахуун, сэлбэг, засварын зардал	10	10,039.7	39,990.0	13,486.0	11,674.9	1,811.1
8	Харилцаа холбооны зардал	11	7,487.7	17,576.0	16,470.8	15,981.5	489.3
9	Зар сургалчилгааны зардал	12	21,348.2	42,900.0	78,437.5	67,075.6	11,361.9
10	Сургалт, судалгаа, шинжилгээний зардал, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалтын санхүүжилт	13	153.1	53,480.0	9,673.0	8,218.4	1,454.6
11	Даатгалын тохиолдлыг шалгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирол үнэлгээний зардал	14		51,255.1	600.0	598.0	2.0
12	Орон нутгийн салбаруудын урсгал зардал	15		147,344.4	28,318.1	6,480.3	21,837.8
	Захиргаа, аж ахуйн зардал				18,068.1	1,041.9	
	Бичиг хэргийн зардал				2,500.0	549.2	
	Даатгал, оношилгоо, татвар				1,250.0	545.1	
	Холбоо				6,500.0	4,344.1	
13	Удирдах зөвлөлийн зардал		26,600.0	28,800.0	23,742.0	23,742.0	-
	<b>Үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийн дүн</b>	16	298,308.8	994,899.2	709,339.9	665,817.4	45,991.0
<b>2. Хөрөнгө оруулалтын зардлын төсөв</b>							
11	Тавилга, техник хэрэгсэл	17	26701.9	42,532.0	60,841.3	55,245.9	5,595.4
	Тавилга, эд хогшил					27,826.8	
	Компьютер, принтер, техник хэрэгсэл					27,419.1	
13	Сургалтын техник, тоног төхөөрмж, хэрэгсэл	18			19,000.0	19,000.0	-
14	Мэдээллийн сангийн сервер, програм хангамж, хөгжүүлэлтийн зардал	19	10200.0	180,283.0	142,973.7	140,264.2	2,709.5
15	Ажлын алба, орон нутгийн шуурхай албадын автомашин худалдан авалт	20		190,000.0	190,000.0	190,000.0	-
	<b>Хөрөнгө оруулалтын зардлын төсвийн дүн</b>	21	36,901.9	412,815.0	412,815.0	404,510.1	8,304.9
	<b>Нийт зардлын төсвийн дүн</b>	22	335,210.7	1,407,714.2	1,122,154.9	1,070,327.5	54,295.9

## АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2013 онд үндсэн үйл ажиллагааны зардалд 665,817.4 мянган төгрөг зарцуулсан, үүнээс цалин хөлс 298,502.2 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 31,305.2 мянган төгрөг, төв оффис, орон нутаг дахь салбаруудын албан конторын түрээсийн зардалд 157,523.5 мянган төгрөг, албан томилолтын зардалд 12,035.1 мянган төгрөг, зам, тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сурталчилгааны зардалд 67,075.6 мянган төгрөг, сургалтын зардалд 8,218.4 мянган төгрөг, холбоо, интернэтийн зардалд 15,981.5 мянган төгрөг, шатахуун, сэлбэг хэрэгслийн зардалд 11,674.9 мянган төгрөг, Удирдах зөвлөлийн гишүүдийн урамшуулал, сургалт, судалгаа, албан томилолтын зардалд 40,996.7 мянган төгрөг, захиргаа аж ахуй, бичиг хэрэг, тээврийн хэрэгслийн татвар, оношилгооны зардал зэрэг бусад зардалд 15,698.5 мянган төгрөг, орон нутгийн салбаруудын урсгал зардалд 6,207.7 мянган төгрөг, даатгалын тохиолдлын үнэлгээний зардалд 598.0 мянган төгрөг тус тус зарцуулав.

Хөрөнгө оруулалтын санхүүжилтээр тайлант хугацаанд 404,510.1 мянган төгрөг зарцуулж, үүнээс мэдээллийн сангийн сервер, програм хангамж, хөгжүүлэлтийн зардалд 140,264.2 мянган төгрөг, орон нутгийн салбаруудад шуурхай албаны зориулалтын 9 ширхэг автомашин худалдан авахад 190,000.0 мянган төгрөг, сургалтын зориулалттай техник хэрэгсэл, ширээ сандал авахад 19,000.0 мянган төгрөг, төв болон орон нутгийн салбарын хэрэгцээнд 55,245.9 мянган төгрөгийн компьютер, тавилга, эд хогшил худалдан авав. 2013 онд үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 43,522.5 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардлын төсвийг 8,304.9 мянган төгрөгөөр нийт 51,827.4 мянган төгрөгөөр хэмнэв.

2013 онд жолоочийн даатгалын сангаас Жолоочийн даатгалын тухай хуулийн 18.1.1, 18.1.2 дахь заалтыг үндэслэн даатгалын тохиолдлын хохирогчид 40,544.1 мянган төгрөгийн нөхөн төлбөр олгож, буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх гэрээ байгуулж, үүнээс 9,725.6 мянган төгрөгийг санд буцаан төвлөрүүлсэн.

2013 онд жолоочийн даатгалын сангийн орлогын гүйцэтгэл 2,816,419.2 мянган төгрөг, зардлын гүйцэтгэл 1,070,327.5 мянган төгрөг болж, жолоочийн даатгалын сангийн ирээдүйд гарах хохирол нөхөх санд 1,746,091.7 мянган төгрөг төвлөрүүлэв.

2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт хөрөнгө 2,331,481.2 мян.төгрөг, үүнээс мөнгөн хөрөнгө 1,819,656.4 мян.төгрөг, авлага 32,028.9 мян.төгрөг, буцаан нэхэмжлэлтэй нөхөн төлбөрийн авлага 30,818.5 мян.төгрөг, эргэлтийн хөрөнгө /БҮТЭЗ/ 14,081.3 мян.төгрөг, үндсэн хөрөнгө 414,714.7 мян.төгрөг, биет бус хөрөнгө /програм хангамж/ 51,000.0 мян.төгрөг тус тус байна.

Хүснэгт №18. 2013 оны жилийн эцсийн санхүүгийн хураангуй тайлан /мян.төг/

Балансын зүйл	2012.12.31		Гүйлгээ		2013.12.31	
	Дт	Кт	Дт	Кт	Дт	Кт
Мөнгөн хөрөнгө	99,479.2		6,665,405.1	4,945,227.9	1,819,656.4	
Авлага	12,000.0		85,013.3	64,984.4	32,028.9	
Бараа материал	5,386.8		63,124.3	54,429.9	14,081.2	
УТЗ тооцоо	13,944.0		40,800.0	54,744.0	-	
Үндсэн хөрөнгө	45,865.5		368,849.2	-	414,714.7	
Биет бус хөрөнгө/програм/			51,000.0	-	51,000.0	
Богино хугацаат өглөг		896.1	493,865.4	498,069.3		5,100.0
Нөөцийн сан		10,000.0	110,047.5	2,426,428.7		2,326,381.2
Хуримтлагдсан үр дүн		165,779.4	2,316,381.2	2,150,601.8		-
<b>БАЛАНС</b>	<b>176,675.5</b>	<b>176,675.5</b>	<b>10,194,486.2</b>	<b>10,194,486.2</b>	<b>2,331,481.2</b>	<b>2,331,481.2</b>

2013 оны санхүүгийн тайлангийн дүгнэлтээр “Жолоочийн даатгалын тухай” хуулийн үндсэн зарчим болон хуулийн 23.1 дэх заалтын дагуу жолоочийн даатгалын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийн болон материаллаг нөөц тодорхой хэмжээгээр бүрдсэн байна.

## 2.5 ГАДААД БОЛОН ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах нь асуудлыг цогцоор шийдвэрлэхэд түлхэц болж байна.*

Тайлант хугацаанд гишүүн даатгалын компаниудад жолоочийн даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад тулгарч буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх цаашид хамтран ажиллах хамтын ажиллагааны хэлбэрийг тогтоох зорилгоор даатгалын компаниудын удирдлага, төлөөлөгч нартай нийт 5 удаа, Зам, Тээврийн яамны Тээврийн хяналт, бүртгэлийн газрын дарга удирдлагатай 3 удаа, Сангийн яамны Даатгалын хэлтсийн дарга удирдлага, асуудал хариуцсан боловсон хүчинтэй 4, Замын цагдаагийн газрын удирдлагатай 10 удаа тус тус нэгдсэн ажил хэргийн уулзалт зохион байгууллаа. Дээрх уулзалтуудаар төрийн байгууллага, даатгалын компаниуд, даатгалын мэргэжлийн оролцогчид хэрхэн үр дүнтэйгээр хамтран ажиллах тухай нэгдсэн ойлголтод хүрч чадсан.

Даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай нягт хамтран ажиллаж 2013 оны 4 дүгээр сар 15-ны өдрөөс эхлэн хоёр сарын аянг зохион байгуулсан. Аяны хүрээнд тээврийн хэрэгслийн оношилгоо, хяналт, зохицуулалтын албаны Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан салбарууд болон Нийтийн тээврийн хэрэгслийн авто оношилгооны газарт Холбооны нэр бүхий мэргэжилтэнг томилон ажиллуулж үйлчлүүлэгч, оношилгооны төвүүдийн ажилтан албан хаагчид болон даатгалын компаниудын даатгалын мэргэжилтэн нарт мэргэжлийн зөвлөгөө өгч, хууль сурталчлан ажилласан. Мөн Замын цагдаагийн газартай хамтран замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 16.3.8, Жолоочийн даатгалын тухай хуулийн 28.1.1 заалтыг хэрэгжүүлж, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдаагүй болон хамрагдсан ч гэрээний хугацаа нь дууссан мөртөө замын хөдөлгөөнд оролцож яваа жолооч нарыг шалгаж илрүүлэх, жолоочийн даатгалд хамруулах, хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх улмаар зам, тээврийн ослын улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч буй иргэдийн эрх ашгийг хамгаалах, хуулийн хэрэгжилтийг хангуулах хамтарсан шалгалтыг Нийслэлд 2013 оны 7 дугаар сарын 25-аас 8 дугаар сарын 05-ны хооронд, 2013 оны 09 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд болон 2013 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 12 дугаар сарын 26 хүртэл 45 хоногийн хугацаатайгаар тус тус зохион байгуулан ажиллалаа. Нийслэлд зохион байгуулсан шалгалтаар нийт 5400 тээврийн хэрэгсэл шалгаж, жолоочийн даатгалд даатгуулаагүй, даатгалын хугацаа нь дууссан үедээ, мөн гэрээнд нэр бичигдээгүй хүн жолоодсон зэрэг нийт 2300 гаруй зөрчил илрүүлж даатгалд хамруулсны дотор газар дээр нь 841 жолоочийг даатгалд хамруулсан байна. Дээрх зөрчилтэй замын хөдөлгөөнд оролцож явсан бусад жолоочийг даатгалд хамруулсны дараа цагдаагийн байгууллагаас хуульд заасны дагуу 953 хүнийг 167.5 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авсан байна. Тайлангийн хугацаанд орон нутгийн салбарууд замын цагдаатай хамтран 13200 гаруй тээврийн хэрэгсэл шалгаж, 1975 зөрчил илрүүлэн жолоочийн даатгалд хамруулан шийдвэрлэсэн байна.

Мөн Баасан гараг бүр “Авто радио 96.3” радиотой хамтран жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын ач холбогдол, түүнд хамрагдсаны ач тус, даатгалын тохиолдол болох үед хэнд хэрхэн хандах, шуурхай албаны үйлчилгээг хэрхэн авах, нөхөн төлбөр авахад анхаарах зүйлс зэрэг иргэдийн сонирхсон асуултад хариулах замаар хууль сурталчлах, жолоочийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг хийж байна.

*Мэргэжил нэгт нөхдийн олон арван жилийн туршлага, асуудал хэрхэн шийдвэрлэсэн нь бид амжилттай ажиллах үндэс суурь болж байна.*

Албан журмын даатгагчдын холбоо бусад улсын дэвшилтэд арга барилыг нэвтрүүлэх, ижил төстэй байгууллагаас туршлага судлах зорилгоор гадаад хамтын ажиллагаанд ач холбогдол өгч ажиллаж ирсэн. БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын зардлаар Солонгосын Даатгалын институтын мэргэжилтэнг 6 сарын хугацаатайгаар урьж, мэдээллийн сангийн програм боловсруулах чиглэлээр ажиллууллаа. Мөн ОХУ-ын туршлага судлах Оросын Автодаатгагчдын холбоотой хамтын ажиллагааг эхлүүлэх зорилгоор Оросын Холбооны Улсын Автодаатгагчдын холбооны төлөөлөгчдийн албан ёсны айлчлалыг 2013 оны 12 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд зохион байгуулж, ОХУ-ын Автодаатгагчдын холбоотой хамтран ЗТЯ, СЗХ, ЗЦГ, Даатгалын зуучлагчдын холбоо, Хохирол үнэлэгчдийн холбоо, Даатгагчдын холбоо болон АЖДХ-ны гишүүн 16 даатгалын компанийн нийт 60 төлөөлөгчийг оролцуулан “ОХУ-ын Жолоочийн хариуцлагын даатгалын эрх зүйн тогтолцоо”-ны тухай сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Хятадын жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагааг хянан зохицуулах байгууллагад хамтран ажиллах хүсэлтээ хүргүүлээд байгаа бөгөөд талууд хамтарсан уулзалтыг энэ онд зохион байгуулахаар зөвшилцөөд байна.

Холбоо дотоод нэгжүүдээр дамжуулан АНУ, ОХУ, Хятад, Солонгос болон Япон улсын болон Тайванийн жолоочийн даатгалын тогтолцоог судалж, дотоод сургалтыг зохион байгуулж байна.

## **ГУРАВ: ДҮГНЭЛТ**

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тогтолцоо нэвтэрснээр тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, даатгалтай эсэхээс үл хамааран авто замын осолд өртсөн гуравдагч этгээд буюу эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэд, байгууллагад нөхөн төлбөр олгож, хариуцлагын даатгалын суурийг амжилттай тавьлаа.

Хууль хэрэгжиж эхэлсэн энэ хугацаанд манай иргэд хуулийн талаар ерөнхий ойлголттой болж, жолоочийн хариуцлагын даатгалын ач холбогдлыг танин мэдэж байгаа боловч иргэдэд мэдээ, мэдээллийг илүү ойртуулах, даатгалын ашиг тус, ач холбогдлыг таниулах, даатгалын зах зээлийг хөгжүүлэх талаар хийх ажил багагүй байна.

Хэдийгээр 2013 онд багагүй ажлыг амжуулсан боловч, цаашид анхаарах, яаравчлан шийдвэрлэх тулгамдсан асуудлууд байсаар байна. Үүнд:

### ***Мэдээллийн сангийн чиглэлээр:***

Даатгалын компанийн төлөөлөгч, зуучлагчид даатгалын гэрээг цахим байдлаар хийж баталгаажуулах болон нөхөн төлбөр өгөх тохиолдол бүрийг мэдээллийн нэгдсэн санд шууд орж байхаар програм боловсруулагдаагүй, даатгагч, зуучлагч бүр нэгдсэн програм ашиглахгүй байгаа явдалд дүгнэлт хийж, холбогдох арга хэмжээ авч байна.

Жолоочийн даатгалын гэрээ байгуулах, нөхөн төлбөр олгохын тулд мэдээллийн хүчирхэг бааз санг бий болгох, мэдээллийн чанарт онцгой анхаарах шаардлагатай байна. Үүний тулд мэдээллийн сангийн програм хангамж, сүлжээг шаардлагын түвшинд хүртэл яаралтай хөгжүүлэх, түүнд зориулж тодорхой төсөл боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай боллоо. Энэ асуудлыг зөвхөн Холбооны түвшинд бус Засгийн газрын түвшинд танилцуулах, шийдвэрлүүлэх нь зүйтэй байна. Энэ чиглэлээр ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна.

Аль ч салбарын үйл ажиллагааг оновчтой удирдахад цаг үеийн үнэн зөв мэдээлэл чухал үүрэгтэй. Гэтэл даатгалын компаниудад жолоочийн даатгалын гэрээ байгуулах, нөхөн төлбөр олгох, даатгалын баталгааны наалтын зарцуулалтын тайлан гаргалтаас үзэхэд дэндүү хайхрамжгүй

хандаж байгааг олон баримтаар нотолж болох байна. Төр, засгаас жолоочийн даатгалын тухай хуулийг баталж хэрэгжүүлсэн нь нийгэмд бий болсон сахилгагүй, хариуцлагагүй байдлыг арилгах, зам, тээврийн ослын улмаас учруулсан амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохиролыг нимгэлэхэд чиглэсэн арга хэмжээний нэг хэсэг мөн. Гэтэл даатгалын компаниудад бэлтгэл хангагдсан эсэхийг үл харгалзан жолоочийн хариуцлагын даатгал хийх зөвшөөрлийг хэт хавтгайруулж олгосон явдлыг эргэн авч үзэх шаардлагатай байна.

Энэ байдлыг шуурхай албаны үйлчилгээ жигд биш, ялангуяа орон нутагт (нийслэлээс бусад) шуурхай албаны үйлчилгээ байхгүй, даатгалын гэрээний болон нөхөн төлбөрийн мэдээллийг цаг тухай бүр мэдээллийн санд оруулдаггүй зэрэг дутагдал нийтлэг байгаагаас харж болно.

#### ***Санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр:***

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.1 дэх заалтын дагуу даатгалын компаниудаас 2011-2013 онд жолоочийн даатгалын санд нийт 923,739.0 мянган төгрөг шилжүүлсэн. Энэхүү хөрөнгө нь Даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны зааварт тусгагдаагүй.

Энэхүү хөрөнгийг даатгалын байгууллагын зардалд хэрхэн хамруулах талаар ААНОАТ-ын хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслийг Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яаманд хүргүүлээд байна.

Орон нутгийн төсвөөс автотээврийн өөрөө явагч хэрэгслийн татварын 10 хувийг хуулийн дагуу жолоочийн даатгалын санд хөрөнгө төвлөрүүлэх эрх зүйн үндэслэл байгаа хэдий ч цаашид орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч, ИТХ-аас баталсан төсвийг жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх, тайлагнах талаар шийдвэрлэх асуудал байна.

Иймд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын сангийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлд тусгах дансны заавар, сангийн үлдэгдэл /нөөц сан байгуулах/ тооцох аргачлалыг яаралтай баталж мөрдүүлэх, Холбооны санхүүгийн тайланг ямар хэлбэрээр гаргаж /Төрийн бус байгууллага, даатгалын байгууллага, төсөвт байгууллага г.м/ тайлагнах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Одоогоор төрийн бус байгууллагад мөрддөг санхүүгийн тайлан гаргах заавар, маягтын дагуу санхүүгийн тайланг гаргаж, тайлагнаж байна.

#### ***Даатгалын сангийн чиглэлээр:***

Даатгалын сангийн орлогын бүрдүүлэлтийг УИХ-аас баталсан хуваарьт хугацаанд төвлөрүүлдэг болгох шаардлагатай байна. Сангийн сайд, Зам, тээврийн сайдын 2013 оны 20/19 тоот хамтарсан тушаалаар “Жолоочийн даатгалын сангийн дансанд хөрөнгө шилжүүлэх тухай” журмыг баталсан. Энэ журмын дагуу Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нар аймаг, нийслэлийн төсвийн хуваарьт тусгагдсан эх үүсвэрийн гүйцэтгэлийг сар тутам тооцож, дараа сарын 10-ны өдрийн дотор Албан журмын даатгагчдын холбооны жолоочийн даатгалын сангийн төвлөрсөн харилцах дансанд шилжүүлнэ” гэж заасан боловч УИХ-аас баталсан хуваарийг орон нутаг дахь ИТХ нь дур мэдэн хасаж батлах, хугацаандаа төвлөрүүлэхгүй байх хүндрэлүүд гарсаар байна. Даатгалын санд төвлөрч буй орлогыг тухайн орон нутагт нь зарцуулж байгаа бөгөөд төвлөрүүлбэл зохих орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлэхгүй байгаа нь даатгалын тохиолдлын улмаас хохирсон иргэдэд нөхөн төлбөрийг хугацаанд нь олгох боломжгүй болох зэрэг эрсдэл бий болох магадлалтай юм.

Иймээс УИХ-аас батлагдсан хэмжээгээр жолоочийн даатгалын санд хөрөнгө төвлөрүүлж байх, төвлөрүүлээгүй бол зохих арга хэмжээ авах тухай журмыг Санхүүгийн зохицуулах хороо шийдвэрлэх нь зүйтэй юм.

Мөн зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглагдах ёстой “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 28.1-д заасан торгуулийн орлогын 50 хувийг жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх эрхзүйн орчин бүрдээгүй байна. Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх тухай эрх зүйн зохицуулалт байгаа хэдий ч төсөвт суулгаж батлагдаагүй гэсэн шалтгаанаар орон нутагт хэрэгжихгүй байна. Энэ нь Аймаг, нийслэлийн ИТХ-аас төсөв батлахдаа торгуулын орлогыг



тооцон төлөвлөдөггүйтэй холбоотой байна. Иймд орон нутгийн төсвийн эрх захирагчдад тодорхой чиглэл өгсөн шийдвэрийг гаргах нь зүйтэй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 302 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ын 2 дугаар зүйл /Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага/-ийн 2.5-д “Жолоочийн даатгалын тохиолдлыг шалгах шуурхай албатай байх” гэсэн заалтыг даатгалын компаниуд болон түүний салбарууд хэрэгжүүлэх үүрэгтэй. Гэтэл даатгалын компаниудад баримтлах эрх зүйн зохицуулалтгүй байгаагаас үйл ажиллагаа нь жигд бус, даатгалын тохиолдлын дуудлага хүлээж авах, үзлэг хийх ажиллагаа нь харилцан адилгүй, хөтөлдөг маягууд нь өөр хоорондоо эрс ялгаатайн дээр шуурхай албаны үүрэг, ач холбогдлын талаар даатгалын компани бүр өөрийнхөөрөө ойлгон ажиллаж байна. “Монгол даатгал”, “Соёмбо” даатгал зэрэг компаниуд өөрийн шуурхай албатай байхад “Гэр” даатгал, “Ган зам” даатгал, “Улаанбаатар хотын” даатгал зэрэг компаниуд шуурхай албагүй, бусад даатгалын компаниуд “Авто СОС” ХХК гэгч байгууллагатай гэрээ байгуулан даатгалын шуурхай үйлчилгээ авч, түүнийг үндэслэн даатгалын нөхөн төлбөр олгож байна. Дээрх шуурхай албадын аль аль нь мөрдөж ажиллах тодорхой журам, зааваргүйгээс “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д заасан “Шуурхай алба нь жолоочоос шалтгаалан гарсан зам, тээврийн ослын талаарх мэдээллийг даатгуулагч, даатгагч, жолооч, хохирогч, иргэдээс хүлээн авч, даатгалын тохиолдлын улмаас хохирогчид олгох нөхөн төлбөрийг шуурхай, үнэн зөв тодорхойлох боломжийг даатгагч, даатгуулагч, жолооч, хохирогчид бүрдүүлэх” чухал үүргийг өөрсдийн үзэмжээр хэрэгжүүлж байна.

Иймд даатгалын компаний шуурхай албаны ажиллах нэгдсэн журмыг нэн яаралтай батлан мөрдүүлэх, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 302 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах, “Авто СОС” зэрэг хөндлөнгийн байгууллагаар даатгалын шуурхай үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрөх эсэх талаар тодорхой шийдвэр гаргуулах саналтай байна.

Холбоо 2013 оны ажлын гүйцэтгэлд дүгнэлт хийж, 2014 онд өнгөрсөн оны амжилтыг ахиулах, хариуцлагын даатгалыг мэдээллийн сүлжээ технологийг ашиглан хурдацтай төлөвшүүлэх зорилт тавин ажиллаж байна.